

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачлагын 2007 оны тайлан талаар хийж буй дүгнэлт

2009 оны 11 дүгээр сарын 26- ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Малайзийн Эрнст Янг аудитын компаниудын консорциумаас гаргасан 2007 оны Монгол Улсын ОУИТБС- ын тайлангийн талаар энэхүү дүгнэлтийг танилцуулж байна.

Энэ тайланд 38 компани хамрагдсан бөгөөд нэгтгэгдсэн татвар, төлбөр, хураамж, хандивын нийт хэмжээ 748 орчим тэрбум төгрөг болж байгаа бөгөөд үүний 80 хувийг Эрдэнэт Үйлдвэр ХХК ганцаар бүрдүүлж байгаа юм. Нэгтгэгдсэн нийт дүн 2007 оны улсын нэгдсэн төсвийн орлогын 40 гаруй хувийг эзэлж байгаа ба бид үүнийг ил болголоо. Гэрээт аудиторын байгууллагаар нотлогдсон, тайлбарлагдаагүй зөрүү нь 775 сая орчим төгрөг болж байгаа нэгтгэгдсэн нийт дүнгийн 0,103 хувь болж байна.

2006 оны нэгтгэл тайланд 25 компани оролцож, нэгтгэгдсэн төлбөрийн дүн 490 орчим тэрбум төгрөг болж байсан нь тухайн оны нэгдсэн төсвийн орлогын 30 орчим хувь байжээ. Анхны тайлангаар гарсан зөрүү нь 25 орчим тэрбум төгрөг байсан нь нэгдсэн дүнгийн 5 гаруй хувийг эзэлж байсан юм. Гэхдээ нарийвчилан нягтлах талаар идэвхтэй ажилласан бол энэ зөрүү багасах бололцоотой байсан гэдгийг хаана хаанаа зөв ойлгох хэрэгтэй байна.

2007 оны тайлангаар нотлогдсон зөрүүнд задлан шинжилгээ хийж үзэхэд татварын эзлэх хувь хэмжээ харьцангуй бага, татварын зөрүүг голлон гаалийн татвар, импортлосон шатах тослох материалын онцгой албан татварын зөрүү үүсгэж байна. Гаалийн татварын хамгийн зөрүү 1,3 сая төгрөг Шинь Шинь компани дээр, хамгийн их зөрүү Эрдэс холдинг компани дээр 143,3 сая төгрөг байгаа нь нотлогдсоноос гадна зөрүү 20 компанийн тайлантай холбогдон гарч байгаа нь нийтлэг байдалтай байна. Татварын зөрүү харьцангуй бага байгаа нь татварын алба, компаниудтай жил татварын тооцоо хийдэг тул тодорхой хяналт байдгийг харуулж байна. Харин татвар, гаалийн байгууллагуудын хооронд улирал бүр тооцоо нийлдэг гэдэг ч тооцоо нь чанартай хийгддэггүй байх магадлалтай байна.

Зөрүүнд төлбөрүүдийн эзлэх хувь хэмжээ бусдаас нилээд өндөр байгаа нь тайлангаар нотлогдож байна. Шанлун компаниас төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зөрүү 423 сая, Бороо гоулд компаниас улсын хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийн зөрүү 280 сая, Монголросцветмет ХХК- аас төлсөн усны төлбөрийн зөрүү 45,9 сая, Шижир алт ХХК- ийн усны төлбөрийн зөрүү 44,8 сая, Монполимет ХХК- ийн усны төлбөрийн зөрүү 44,4 сая төгрөг болж

байна. Газрын төлбөрийн зөрүү харьцангуй их биш ч, 12 компани дээр зөрүүтэй байгаа нь нотлогдож байна. Газар, усны төлбөрийг орон нутагт ихэвчлэн төлдөг онцлогтой тул мэдээллийн урсгалын сул байдлаас зөрүү өндөр байх магадлалтай гэж үздэг болох юм. Төлбөрүүдийн тооцоог Ашигт малтмал, татварын алба, компаниуд хамтран улирал бүр хийж явбал зөрүү гарах нь багасах магадлалтай.

Хураамж үйлчилгээний хөлстэй холбогдсон зөрүү харьцангуй өндөр хувь хэмжээг эзэлж байгаа нь мөн л нотлогджээ. Хамгийн их зөрүүтэй компаниудад Петро Чайна Дачин Тамсаг, Бороо гоулд ХХК оржээ. Тэдгээрийн зөрүү 166 сая, 67 сая байна гэж тус тус нотлогдсон байна. Засгийн газрын бараг бүх шатны байгууллагуудад хураамж, үйлчилгээний хөлс төлдөг учир Засгийн газрын байгууллагууд энэ төрлийн мэдээ тайланг дутуу, хангалтгүй гаргадагтай холбоотой байж болно. Хураамж үйлчилгээний хөлсийг бүх шатанд авч, нэг ёсны хүнд суртал, захиргааны хэрэгсэл болгож байгаа учир ирээдүйд хураамж үйлчилгээний хөлсний тоо багасахын хирээр тайлангаас ажжмаар хасах нь оновчтой байх магадлалтай.

Төрийн байгууллагуудад үзүүлсэн хандив тусламжийн зөрүүт байдал харин энэ удаа харьцангуй бага гарсан гэж үзэж болно. 2006 оны тайлангаар нотлогдсон хандив тусламжийн зөрүү 3,9 тэрбум байснаас, хамаагүй бага байгаа нь нотлогдсон хэдий ч, зөрүүнүүдэс дурдвал Бороо гоулд компаниас яам, агентлагуудад үзүүлсэн гэх 60,5 сая, аймагт үзүүлсэн гэх 39,9 сая, сумын хөгжилд олгосон гэх 571 сая төгрөг гээд нилээд зөрүү байгаа нь илэрлээ. Хандив тусламжтай холбогдсон зөрүү 25 компанийн тайлантай холбогдон гарчээ. Хандив өгөх, авах журмыг бий болгохгүй бол энэ чиглэлээр зөрүү байнга байх магадлалтай байна.

Байгаль хамгаалахад зарцуулсан зардлын зөрүүтэй байдал 24 компаниаар холбогдон гарсан нь ихээхэн нийтлэг, бүгдийг хамарсан шинжтэй нь байна. Хамгийн их зөрүүтэй нь Гацуурт ХХК, 293 сая төгрөг, зөрүүний дундаж 70 орчим сая төгрөг болж байна. Байгаль орчины зардлыг тооцоо нийлэх ажиллагаа компани, байгаль орчин, ашигт малтмалын байгууллагуудын хооронд байдаггүйтэй холбоотой байж магадгүй байна. Тооцоог мэргэжлийн хяналт, ашигт малтмал, байгаль орчины байгууллага, компаниуд хамтарч тогтмол хийж, нөхөн сэргээлтийн ажлын хяналтыг сайжруулал зөрүүний байдал багасах магадлалтай байна.

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын
ажлын алба